



**ЗАВХАН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 08 өдөр

Дугаар 1/45

Улиастай


Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.1 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй Халуун сэтгэл эцэг эхийн холбоо төрийн бус байгууллагын хүүхэд харагч багш нарын цалин, урамшууллын зардалд 6,700,000 (зургаан сая долоон зуун мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэгт шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Г.Мягмарсүрэн)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Д.Бадамсүрэн)-т үүрэг болгосугай.

ДАРГА  ТӨНӨРБАЯР

D/Захирамж docx

8109010190